



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2023. 10.03 № 3 / 3804

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「 Хүний хувийн мэдээлэл хамгаалах  
хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, тус хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий этгээд нь харилцагч, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулах болон аливаа хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхдээ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна. Үүнд:

1. Хүний хувийн мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа мэдээллийн эзнээс бичгээр (цаасан, эсхүл цахим хэлбэрээр) зөвшөөрөл авсан байх;

2. Мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл, зорилгыг ойлгомжтой, тодорхой тайлбарлах, мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээлэл, цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт, хугацаа, мэдээллийг нийтэд ил болгох эсэх, мэдээллийг бусдад дамжуулах эсэх, дамжуулахаар бол дамжуулах этгээд, дамжуулах мэдээллийн жагсаалт, зөвшөөрлөө цуцлах хэлбэр зэргийг зайлшгүй мэдээллийн эзэнд танилцуулах;

3. Мэдээллийн эзэн болон мэдээллийг хуульд заасны дагуу, эсхүл иргэний үнэмлэх, түүнтэй адилтгах бичиг баримтаар таньж, баталгаажуулах;

4. Мэдээллийн эзэн мэдээлэл цуглуулахад зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд үүсэж болох үр дагаврыг тайлбарлах;

5. Мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийг засах, өөрчлөх, устгах, энэ талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх;

6. Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд шийдвэр гаргах, түүнээс гарах үр дагаврын талаар мэдээллийн эзэнд тайлбарлах;

- 7.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах дотоод журам баталж, мөрдүүлэх;
- 8.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахтай холбоотой гомдол гаргах эрхийн талаар мэдээллийн эзэнд тайлбарлах, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж, хариу мэдэгдэх;
- 9.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар бүртгэл хөтлөх, үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг хадгалах;
- 10.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор төрийн эрх бүхий байгууллагаас хүний хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор дахин давтагдахгүй иргэний бүртгэлийн дугаарыг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлсэн тул цаашид иргэний регистрийн дугаарыг бус иргэний бүртгэлийн дугаарыг ашиглах.

Мөн тус Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, бүртгэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд нь хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, болон аюулгүй байдлыг хангах, хамгаалах үйл ажиллагааныхаа явцад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн тохиолдолд зөвшөөрөл, бүртгэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, улмаар Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээх нөхцөл бүрдэж болзошгүйг анхааруулж байна.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ